



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/205

Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгагдсан Баян-Агт сумын Цэгээн, Хагийн нуур, Баяннуур сумын Баян нуур, Хишиг-Өндөр сумын Хонхор нуур, Могод сумын Загаст нуурыг сэргээх судалгааны ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Жишиг проект” ХХК-тай 14 500 000 /арван дөрвөн сая таван зуун мянга/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т үүрэг болгосугай.
2. Ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, чанарын өндөр түвшинд хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т даалгасугай.
3. Энэхүү ажлын санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу 2018 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ